

**Сумдын Засаг дарга, төсөвт байгууллагуудын дарга,  
нягтлан бодогч нарт**

Манай байгууллагын санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч нар корона вируст цар тахлын үед цахимаар ажиллаж байгаа бөгөөд энэ үеэр сумдын санхүүгийн ажилтнуудаас асууж байгаа асуултуудад Төрийн албаны салбар зөвлөл болон ЗДТГ-ын мэргэжилтнүүдтэй хамтран учирч болох эрсдлээс урьдчилан сэргийлэх зорилгоор дараах хариулт, зөвлөмжийг хүргэж байна. Үүнд:

**Асуулт 1.** Санхүүгийн ажилтнуудыг шагнаж урамшуулахад Сангийн сайдын 2012 оны 294 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогч нарт тавигдах шаардлага шалгуур журам”-ын 5.1. “Анхан шатны болон нягтлан бodoх бүртгэлийг бүрэн хөтөлж, улирлын болон жилийн санхүүгийн тайлан, тэнцэл, төсвийн гүйцэтгэлийн мэдээг цаг хугацаанд нь чанартай, бүрэн гаргаж, өр авлагагүй ажилласан төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийг Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн ажилтныг шагнах журам”-ын дагуу шагнаж урамшуулна гэж заасан байгааг үндэслэж болох уу?

**Хариулт 1.** Сангийн сайдын 2006 оны 292 тоот тушаалаар батлагдсан “Төрийн өмчит аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн ажилтныг шагнах журам”-ын 2.1. Төрийн өмчит аж ахуйн нэгж, төсөвт байгууллагын ерөнхий менежер нь “Төсвийн байгууллагын удирдлага, санхүүжилтийн тухай” хуулийн 49 дүгээр зүйлийг үндэслэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын нягтлан бodoх бүртгэлийн ажилтны ажлыг дүгнэсэн шийдвэр гаргаж, байгууллагын нөөц бололцоонд тулгуурлан улирал бүр шагнаж болно.

2.2. Нягтлан бodoх бүртгэлийн ажилтнуудад олгох шагналын хэмжээг “Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль”-д заасны дагуу тухайн байгууллагын ерөнхий менежер тогтооно гэж заасан байдаг. Төсвийн байгууллагын удирдлага санхүүжилтийн тухай хууль нь 2013 онд хүчингүй болсон тул дээрх заалтуудыг хэрэглэх боломжгүй болсон. Шинээр журам гараагүй болно.

**Зөвлөмж 1.** Санхүүгийн ажилтнуудад мөнгөн урамшуулал олгоходоо Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ыг баримтална. Энэ журмаар салбар бүрээр тусдаа мөрдөж байсан мөнгөн урамшууллын журмуудыг нэгтгэн баталсан. / боловсрол, эрүүл мэнд, бусад төрийн албан хаагчид /

Шагнал олгоходоо дээрх тогтоолын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид шагнал олгох журам”-ыг баримтална. Мөнгөн урамшуулал нь тухайн байгууллагын цалингийн сангаас, мөнгөн шагнал нь 1 удаагийн шагнал урамшуулал, тэтгэмж, урамшууллын зардлаас гарна гэдгийг анхаарах хэрэгтэй.

**Асуулт 2.** Сумын Засаг даргын захирамжаар “2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэлийн болон санхүүгийн тайланг цаг хугацаанд нь чанартай үнэн зөв бүрэн гаргаж Аудитын байгууллагаас “Зөрчилгүй” санал дүгнэлт аван үр дүнтэй ажилласан сумын санхүүгийн албаны дарга, байгууллагын дарга, нягтлан бодогч, эд хариуцагч нарт 1-1,5 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний урамшуулал өмнөх жилд олгосон. Энэ жил “Зөрчилгүй” дүгнэлт авсан учир урамшуулал авч болох уу?

**Хариулт 2.** Болохгүй. 2019 онд байгууллагын дарга, нягтлан бодогч, эд хариуцагч нарт хавтгайруулан цалингийн сангийн хэмнэлтээс 1 сарын цалингийн урамшуулал олгосон байсан. Санхүүгийн хяналт шалгалтаар зөрчилтэй гарсан байгууллагуудын төсвийн эрх захирагч нараар төсөвт хохирол учруулсан шийдвэр гаргасан гэсэн үндэслэлээр дээрх урамшууллыг төлүүлэх эрсдэл үүссэн байгаа. 2019 онд 111-н төсөвт байгууллагуудад хийгдсэн санхүүгийн хяналт шалгалтаар 4,372,888,6 мянган төгрөгийн зөрчил илэрсэнээс аймгийн төсвийн орлогод оруулахаар санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагчийн 223,226.3 мянган төгрөгийн акт тогтоож, 4,149,662.3 мянган төгрөгийн зөрчлийг дахин давтан гаргахгүй байхаар улсын байцаагчийн албан шаардлага бичигдсэн. Шалгагдсан байгууллагын 85,6 % буюу 95 байгууллага зөрчилтэй шалгагдсан байна.

Байгууллагын төсвийн шууд захирагч, санхүүгийн албаны дарга, , нягтлан бодогч, эд хариуцагч нар нь Монгол улсын Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйл. Төсвийн шууд захирагч, түүний бүрэн эрх, Нягтлан бodoх бүртгэлийн

тухай хуулийн 20 дугаар зүйл. Ерөнхий нягтлан бодогчийн эрх, үүрэг 2012 оны 294 тоот тушаалаар батлагдсан “Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогч нарт тавигдах шаардлага шалгуур журам”-ын Дөрөв. Төсвийн ерөнхий, ахлах нягтлан бодогчийн эрх, үүрэг, Сангийн сайдын 2000 оны 69 тоот тушаалаар батлагдсан “Эд хариуцагчийн эрх, үүргийн дүрэм”, мөн тухайн ажлын байрны албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргийг хэрэгжүүлж эрхийг эдэлж аливаа санхүүгийн “Зөрчилгүй” ажиллах үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлсэний төлөө давуу байдал үүсгэн бусад төрийн албан хаагчдаас тусдаа шийдвэр гаргуулан мөнгөн урамшуулал авч байгаа нь Төсвийн тухай хуулийн 6.4.1. төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, 16.5.3. батлагдсан цалингийн сан орон тооны хязгаарт багтаан төсвийн байгууллагын орон тоо, ажиллагсадын цалин хөлсийг тогтоох, 45.2. Төсвийн захирагчийн төсвийн дараах зарцуулагдаагүй үлдэгдлийг төсвийн хэмнэлтэд тооцохгүй бөгөөд тухайн үлдэгдлийг тухайн шатны төсвийн ерөнхий дансанд төвлөрүүлнэ: Авлигын эсрэг хуулийн 7 дугаар зүйлийн 7.1-д ”нийтийн албан тушаалтанд авлигын дараах зөрчлийг хориглоно: 7.1.4. төсвийн болон хандив, тусlamжийн хөрөнгийг зориулалтын бусаар зарцуулах; 7.1.7. албан тушаалын байдлаа ашиглан эд хөрөнгө олж авах, давуу эрх эдлэх... гэж заасныг тус тус зөрчиж албан тушаалын бүрэн эрхээ ашиглан өөртөө давуу байдал үүсгэн давуу эрх эдэлж байгаа ноцтой зөрчил мөн.

- **Зөвлөмж 2:** Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам”-ын 1.2.1. төсвийн ерөнхийлөн захирагч нь харьяа байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээ, ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төсвийн төвлөрүүлэн захирагч болон төсвийн шууд захирагчид; 1.2.2. төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид тус тус шийдвэр гарган олгоно.

- Дээрх журмын 2.2. Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 40 хувиас хэтрэхгүй байна гэж заасан.  
Энэ асуултад нэмж доорх тайлбарыг хийе.
- Төрийн аудитын байгууллага нь “санхүүгийн тайланд аудит” хийж шалгагдагч этгээд санхүүгийн тайлангаа холбогдох хууль тогтоомж, стандарт, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн актын шаардлагад нийцүүлэн үнэн зөв, шударгаар тайлагнасан эсэхэд аудит хийж баталгаажуулж холбогдох дүгнэлт өгдөг.
- Санхүүгийн хяналт, дотоод аудитын байгууллага нь төсөв, санхүүгийн холбогдолтой хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгийг зүй зохистой, үр ашигтай зарцуулсан байдал, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн үйл ажиллагаа явуулдаг гэдгийг ялгаж ойлгох хэрэгтэй.

**Асуулт 3:** Тэтгэвэр тогтоолгоод цааш үргэлжлүүлэн ажиллаж байгаа төрийн жинхэнэ албан хаагчийн цалин хөлсийг яж тооцох вэ ?

**Хариулт 3:** Төрийн албаны тухай хуульд төрийн улс төрийн албан хаагчаас бусад төрийн албан хаагч өндөр насын тэтгэвэр тогтоолгоод үргэлжлүүлэн ажиллах тухай ойлголт байхгүй болсон. 2019 онд Төрийн албаны Төв зөвлөлөөс гаргасан зөвлөмжийн дагуу короно вирусын цар тахлын үед төрийн албан хаагчийн нөөц бүрүүлэх өрөнхий болон тусгай шалгалтууд явагдаж чадахгүй байгаатай холбогдуулан төрийн албанд тэтгэвэр тогтоолгосон хүмүүс түр ажиллаж байгаа. Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэж байгаа өндөр насын тэтгэвэр тогтоолгоод ажиллаж байгаа хүнд зөвхөн үндсэн цалинг олгоно. Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журам”-ын 2.3 дахь эаалтыг үндэслэн тухайн албан тушаалын цалинг олгоно. Ингэхдээ тухайн албан тушаалын ангилалын аль шатлалаар цалинжуулахыг төсвийн захирагч шийднэ. Бусад нэмэгдлийг олгохгүй. Тэтгэвэр тогтоолгож байна гэдэг нь ажилтан өөрийнхөө

санаачлагаар ажлаасаа чөлөөлөгдөж байна гэсэн үг юм. Иймд тухайн ажлын байранд тавигдсан шалгуурыг хангасан төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэнээс нөхөх ёстoy .

**Зөвлөмж 3:** Монгол улсын “Төрийн албаны тухай” хууль, Засгийн газрын 2019 оны 9 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин урамшуулалт олгох журам”-ыг баримтална. Тэтгэвэр тогтоолгож байна гэдэг нь ажилтан өөрийнхөө санаачлагаар ажлаасаа чөлөөлөгдөж байна гэсэн үг юм. Иймд тухайн ажлын байранд тавигдсан шалгуурыг хангасан төрийн албаны нөөцөд бүртгэлтэй иргэнээс нөхөх ёстoy .

**Асуулт 4:** Тэтгэвэр тогтоолгоод цааш үргэлжлүүлэн ажиллаж байгаа улс төрийн болон төрийн үйлчилгээний албан хаагчийн цалин хөлсийг яаж тооцох вэ ?

**Хариулт 4.1:** Улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон албан ажлын онцгой нөхцөлийн, докторын зэргийн нэмэгдлийг бүрэн олгоно.

**Хариулт 4.2:** Үйлчилгээний албан тушаалын ажлын сул байр гарсан тухай 14 хоногт багтаан нийтэд зар тавьж сонгон шалгаруулалт явуулан, хэрэв ажлын байрны шаардлага хангасан хүн ирээгүй тохиолдолд өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хүнийг түр хугацаагаар үргэлжлүүлэн авч ажиллуулж болно. Заавал

баримтжуулсан байх шаардлагатай. Энэ үед хөдөлмөрийн хугацаатай гэрээ байгуулж, гэрээнд цалин хөлсийг хэрхэн зохицуулж, тооцож олгохыг зааж өгөх ёстoy . Жишээ нь илүү цагийн хөлс, бусад нэмэгдэл хөлсний талаар. Гэхдээ энэ нь Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолоор батлагдсан төрийн албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмуудын хүрээнд шийдвэрлэгдсэн байх ёстoy .

**Зөвлөмж 4:** Монгол улсын “Төрийн албаны тухай” хууль, Хөдөлмөрийн тухай хуулийг тус тус баримтлах.

**Асуулт 5:** Тэтгэвэр тогтоолгоод үргэлжлүүлэн ажиллаж байгаа төрийн албан хаагчийн амралтын нөхөн олговрыг яаж бodoх вэ?

**Хариулт 5:** Бусад төрийн албан хаагчдын нэгэн адил Хөдөлмөрийн тухай хуульд зааснаар тооцож олгоно.

Асуултад хариулсан:

Санхүүгийн хяналт, аудитын албаны дарга,  
Санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч  Б.Саруул

Төв аймаг дахь Төрийн албаны салбар зөвлөлийн  
нарийн бичгийн дарга 

Г.Мөнхгэрэл

ЗДТГ-ын Хууль зүйн хэлтсийн ахлах мэргэжилтэн  
 Б.Оюунцэцэг

Анхаарал тавьсан та бүхэнд баярлалаа.